

2015-09-14

Говьсүмбэр аймгийн нийгэм,эдийн засгийн байдал (2015 оны 8-р сарын байдлаар)



I.Нийгмийн байдал

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2016 оны 8 сард 183 байгаагийн 124 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 347 буюу 65.4 хувиар, өмнөх сарынхаас 120 буюу 39.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Эхний 8 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст 98 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх сараас 12 буюу 13.9 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 160 буюу 62.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хөдөлмөрийн хэлтсээр эхний 8 сард 63 иргэн ажилд зуучлуулсны 39 нь буюу 61.9 хувь эмэгтэйчүүд байлаа.



II. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 8 дугаар сард 4081.9 сая төгрөг, зарлага 5101.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 373.9 сая төгрөг буюу 8.4 хувиар буурч, зарлага 185.9 сая төгрөг буюу 3.7 хувиар өслөө.Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 8 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 373.9 сая төгрөгөөр буурахад тэтгэврийн орлого 279.7 сая төгрөг буюу 10.0 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.Нийгмийн даатгалын сангийн зарлага 2016 оны эхний 8 дугаар сард 5101.2 болж, өмнөх оны мөн үеийнхээс 185.9 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 294.0 сая төгрөг буюу 8.3 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.



III.Эрүүлмэнд

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 8 сарын байдлаар 316 эх амаржиж 2015 оны мөн үетэй харьцуулахад 25 буюу 8.6 хувиар төрөлт нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 318 үүнээс 157 нь хүү, 161 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амьд төрсөн хүүхэд 26 буюу 8.9 хувиар тус тус өссөн байна.



IV.Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 8 сард 140 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2 буюу 1.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 7 буюу 13.2 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2016 оны 8 дугаар сард өмнөх сарынхаас 0.7 пунктээр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 3.6 пунктээр, жилийн эцсийнхээс 2.5 пунктээр өссөн байна.



VI. Орон нутгийн төсөв

2016 оны эхний 8 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 10394.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 9958.5 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 1470.3 сая төгрөг буюу 17.3 хувиар өсчээ. Аймгийн төсвийн нийт зарлага 10620.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 8781.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 1838.9 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 196.1 сая төгрөг буюу 2.3 хувиар өссөн байна.2016 оны эхний 8 сарын байдлаар авлагын үлдэгдэл 16.4 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 468.1 сая төгрөг байна.



VII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлтэгч малын 150604 буюу 88.0 хувь нь 2016 оны 8 дугаар сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 92.0 хувь, эм ямаа 86.3 хувь, үнээний 76.7 хувь, ингэний 52.4 хувь, гүүний 67.0 хувь нь төллөсөн бөгөөд 2016 оны 8 сарын байдлаар 148445 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 17123 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Төл бойжилт 97.8 хувьтай байна.



VIII.Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны эхний 8 сард 27137.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4401.5 сая төгрөг буюу 19.3 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарын гаргалт нь 4367.4 сая төг буюу 20.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 25321.6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3059.0 сая төгрөг буюу 13.7 хувиар өслөө.

Материал бэлтгэсэн: Мэргэжилтэн.....Б.Дуламсүрэн